



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 1151

Амардалай

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дах заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дах заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтууд болон газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дэлгэрцогт сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэр (Цамын усны зүүн хойно)-д байршилтай 150000 м.кв (15 га) жимс, жимсгэний усалгаатай тариалангийн зориулалттай газрын эзэмшигч иргэн Доржсүрэн овогтой Бат-Очир (ЗЕ61122511) нь 2022 оны 03 дугаар сарын 14-ны өдөр нас барсан. Иймд хүү Бат-Очир овогтой Энхбаяр (ЗК05232415)-т уг газрыг өмнөх эзэмшигчийн газрын зориулалт, хугацаагаар буюу 7 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/25 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

3.Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгон газрын ашиглалтад хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Д.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

4.Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүй зориулалтын дагуу эзэмшихийг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ